

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

Сонгон шалгаруулах журмыг
шинэчлэн батлах тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.6, 14.9.11 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлыг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгох шалгаруулах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад даалгасугай:

2.1. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-д:

2.1.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4-т заасан эрхийн хүрээнд тогтоосон эмнэлгийн ба сувиллын орны дээд хязгаар, улсын хэмжээнд тусламж, үйлчилгээ үзүүлэх болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, уг мэдээллийн санд бодит цагийн горимоор хандах, төрийн албаны зөвлөлийн эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчийн мэдээллийн нэгдсэн санд хандах боломжийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт олгох, нэгдсэн мэдээллийн сан бүрдэх хүртэлх хугацаанд өөрчлөлт орсон мэдээлэл бүрийг тухай бүр хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

2.2. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт:

2.2.1. Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3-т заасны дагуу эмнэлгийн орыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хязгаарт багтаан зохицуулах хүрээнд зөвшөөрөл олгосон орны тоог өөрийн нутгийн эрүүл мэндийн байгууллага тус бүрээр, орон нутгийн хэмжээнд олгосон тусгай зөвшөөрлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, уг мэдээллийн санд бодит цагийн горимоор хандах боломжийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт олгох, нэгдсэн мэдээллийн сан бүрдэх хүртэлх хугацаанд өөрчлөлт орсон мэдээлэл бүрийг тухай бүр хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

2.3. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (С.Энхболд)-д:

2.3.1. Сонгон шалгаруулалтын бэлтгэл ажлыг хангаж, батлагдсан журмын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулах

2.3.2. Сонгон шалгаруулалтаар зарласан тусламж, үйлчилгээг үзүүлэх нөөц, хүчин чадал, чадавх, чадамжийг үнэлэх “ерөнхий шалгуур” тус бүрд хамаарах шалгуур үзүүлэлт, эрүүл мэндийн даатгалын сангаас зардлыг нь хариуцах тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад заагдсан тусламж, үйлчилгээ бүрд хамаарах “нэмэлт шалгуур”-ыг боловсруулан батлах, шаардлага үүссэн тохиолдолд тухай бүр шинэчлэх

2.3.3. Сонгон шалгаруулалтын үнэлгээнд шаардлагатай дараах мэдээллийн санг үүсгэх, шинэчлэх:

- 2.3.3.1. Орны зөвшөөрлийн мэдээллийн сан
- 2.3.3.2. Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн мэдээллийн сан
- 2.3.3.3. Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн мэдээллийн сан
- 2.3.3.4. Эмч, эмнэлгийн мэргэжилтний эмчлэх, сувилах, эм барих тусгай зөвшөөрлийн мэдээллийн сан
- 2.3.3.5. Төрийн албан хаагчийн хүний нөөцийн мэдээллийн сан
- 2.3.3.6. ЭМДЕГ-тай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээг дүгнэсэн, гэрээний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн сүүлийн 3-н жилийн үнэлгээний мэдээллийн сан
- 2.3.4. Сонгон шалгаруулалтыг цахимаар зохион байгуулах цахим программ хангамжийг хөгжүүлэх, ашиглах

2.4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 02 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

2.5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба (Ц.Сарантуяа)-д даалгасугай.

ДАРГА

Ж.ЧИНБҮРЭН

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ЗАРДЛЫГ НЬ ХАРИУЦАХ ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмаар Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (цаашид “ЭМДЕГ” гэх) нь эрүүл мэндийн даатгалын сангаас зардлыг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага (цаашид “Тусламж, үйлчилгээ үзүүлэгч” гэх) -ийг сонгон шалгаруулах (цаашид “сонгон шалгаруулалт” гэх) зарчим, үе шат, шалгуур, үйл явц, хариуцлага болон холбогдох бусад харилцааг зохицуулна.

1.2 Журмын зорилго нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.14-т зааснаар чанартай, хүртээмжтэй, зардлын хувьд үр ашигтай тусламж, үйлчилгээг иргэд, даатгуулагчдад эрх тэгш, тасралтгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийн оновчтой зарцуулалтыг хангахад оршино.

1.3 Сонгон шалгаруулалтыг төрийн болон хувийн хэвшлийн аливаа өмчийн хэлбэр харгалзахгүйгээр тэгш боломжоор хангана.

1.4 Энэхүү журам нь бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зохицуулагдана.

1.5 Энэхүү журмын зохицуулалтад Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 17 дугаар 17.1-т заасан улсын төсвөөр санхүүжүүлэх тусламж, үйлчилгээнд хамаарахгүй бөгөөд ЭМДЕГ нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийг сонгон шалгаруулахгүйгээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээг байгуулна.

1.6 Энэхүү журмаар зохицуулах сонгон шалгаруулалтыг гурван жилд 1 удаа зохион байгуулах бөгөөд хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, тэгш байдалд үр нөлөө үзүүлж буй тусламж, үйлчилгээний чиглэлээр нэмэлт сонгон шалгаруулалтыг зохион байгуулж болно.

Хоёр. Сонгон шалгаруулалтын зарчим

2.1 Ил тод байдал. Сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг бүх төрлийн мэдээллийн сувгаар дамжуулан олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлнэ.

2.2 Өрсөлдөөнт байдал. Тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн хоорондын чанар, хүртээмж, үр ашиг, нэгдмэл, цогц, тасралтгүй байдалд суурилсан бодит өрсөлдөөнийг дэмжинэ.

2.3 Шударга, тэгш боломж. Бүх тусламж, үйлчилгээ үзүүлэгчдэд ижил нөхцөл, шалгуур тавина.

2.4 Гүйцэтгэлд суурилсан байдал. Тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн сонгон шалгаруулалтаас өмнө үзүүлж байсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үр дүнгийн гүйцэтгэлийг харгалзана.

2.5 Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байдал. Сонгон шалгаруулалт нь хүний хүчин зүйлээс ангид, цахим технологид суурилсан байх ба зохион байгуулж буй албан тушаалтнуудыг ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.

Гурав. Сонгон шалгаруулалтад хамрагдах урьдчилсан нөхцөл ба тусламж, үйлчилгээний хүрээ

3.1 Дараах урьдчилсан нөхцөлийг хангасан тусламж, үйлчилгээ үзүүлэгч сонгон шалгаруулалтад оролцоно.

3.1.1 Хуулийн этгээд байх

3.1.2 Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх

3.1.3 Магадлан итгэмжлэгдсэн байх

3.1.4 Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах хугацаанд эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн өргүй байх

3.1.5 Сонгон шалгаруулалтын үнэлгээний эцсийн дүн гарахаас 14 хоногийн өмнө татварын өргүй байх

3.1.6 Нэмэгдсэн өртгийн албан татварын удирдлагын систем (НӨАТУС)-д холбогдсон, тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн цахим мэдээллийн систем нь ЭМДЕГ-ийн цахим мэдээллийн системд хандах техникийн нөхцөлийг бүрэн хангасан байх.

3.2 Сонгон шалгаруулалтад Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс тогтоосон эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад багтсан дараах төрлүүд хамрагдана:

3.2.1 Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ

3.2.2 Амбулаторийн үзлэг, хяналт, оношилгоо, шинжилгээ, эмчилгээ

3.2.3 Хорт хавдрын химийн болон туяаны өдрийн эмчилгээ;

3.2.4 Өдрийн эмчилгээ, үйлчилгээ

3.2.5 Сэргээн засах тусламж, үйлчилгээ

3.2.6 Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ

3.2.7 Жирэмсний 37 долоо хоногоос өмнөх ба төрсний дараах үеийн хавсарсан эмгэгийн эмчилгээ

3.2.8 Жирэмсэн, төрөлт, төрсний дараах үетэй холбоотой эх барихын тусламж, үйлчилгээ

3.2.9 Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ

3.2.10 Түргэн тусламж

3.2.11 Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо

3.2.12 Сувилаас үзүүлэх тусламж, үйлчилгээ

3.3 Сонгон шалгаруулалтад оролцогч тусламж, үйлчилгээ үзүүлэгч нь 3.2-т заасан тусламж, үйлчилгээний төрлийн хүрээнд сонгон шалгаруулалтад оролцох бөгөөд 3.1-т заасан урьдчилсан нөхцөлийг бүрэн хангасан байна.

3.4 Сонгон шалгаруулалтад оролцохоор хүсэлт гаргагч тусламж, үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү журмын 3.1-т заасан урьдчилсан нөхцөлийг бүрэн хангасан байх бөгөөд эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд заасан тусламж, үйлчилгээний хүрээнд сонгон шалгаруулалтад оролцоно.

Дөрөв. Сонгон шалгаруулалтын зохион байгуулалт, үе шат

4.1 Сонгон шалгаруулалт нь дараах хоёр гурван үе шаттай явагдана.

4.1.1 Нэгдүгээр үе шат. Тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн байгууллагын үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хүлээн авах

4.1.2 Хоёрдугаар үе шат. Сонгон шалгаруулалтад оролцогч тусламж, үйлчилгээ үзүүлэгч нь энэ журмын 3.2-т заасан тусламж, үйлчилгээний төрлийн хүрээнд хүсэлт гаргасан тусламж, үйлчилгээг үзүүлэх нөөц, хүчин чадал, чадавх, чадамжийг шалгуур үзүүлэлтээр үнэлэх

4.1.3 Гуравдугаар үе шат. Сонгон шалгаруулалтаар зарласан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлыг нь хариуцах тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад заагдсан тусламж, үйлчилгээг бүрд хамаарах нарийвчилсан шалгуурын дагуу үнэлэх

4.2 Тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн байгууллагын үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү журмын нэгдүгээр хавсралтад заагдсан хүснэгтийн загварын дагуу хүлээн авна.

4.3 Тусламж, үйлчилгээ үзүүлэгч нь байгууллагын үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өгөхдөө хууран мэхлэх оролдлого хийсэн нь үнэлгээний явцад тогтоогдсон тохиолдолд сонгон шалгаруулалтаас шууд хасагдах нөхцөл болно.

4.4 Тусламж, үйлчилгээ үзүүлэгч нь байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг энэхүү журмын 4.2-т заасан хүснэгтийн загварын дагуу цахим хэлбэрээр ирүүлэх бөгөөд бүх мэдээллийн үнэн зөв байдлыг тухайн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын дарга, захирал гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

4.4 Сонгон шалгаруулалтад оролцогчийн хүсэлт гаргасан тусламж, үйлчилгээг үзүүлэх нөөц, хүчин чадал, чадавх, чадамжийг үнэлэх шалгуурыг “ерөнхий шалгуур” гэх бөгөөд уг шалгуурыг дараах үнэлгээний аргачлалаар үнэлнэ.

д/д	Шалгуур	Агуулга	Жин (хувиар)
1	Хүний нөөц, чадавх	Эмч, мэргэжилтний шаардлагатай тоо, мэргэшсэн байдал	10%
2	Дэд бүтэц	Хүсэлт гаргасан тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн шаардлагууд	10%
3	Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл	Хүсэлт гаргасан тусламж, үйлчилгээг үзүүлэх техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдал	10%
4	Чанар, аюулгүй байдал	Чанарыг тасралтгүй сайжруулах арга хэмжээний үр дүн, чанарын шалгуур үзүүлэлтийг бодит цагийн горимоор хяналтын самбарын тусламжтайгаар үнэлдэг байдал, тусламж, үйлчилгээний тохиолдол дээр суурь шалтгааны дүн шинжилгээ хийдэг тогтвортой тогтолцоо, эмнэл зүйн	20%

		эрсдэлийн тогтвортой удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн байдал	
5	Хүртээмж, тэгш байдал	Хүсэлт гаргасан тусламж, үйлчилгээ нь эмнэл зүйн хувьд цогц, нэгдмэл тасралтгүй байх нөхцөлийг хангасан байдал, газар зүйн байршил, орлого, нийгмийн байдлаас шалтгаалсан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүн амын цөөнхөд тусламж, үйлчилгээ тэгш, хүртээмжтэй хүргэх төлөвлөлт	10%
6	Өртөг, зардлын үр ашиг	Өөрийн байгууллагын үзүүлдэг тусламж, үйлчилгээний нэгж өртгийг тооцоолсон тооцоолол, ЭМД-ын сангаас зардлыг нь хариуцах тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад заагдсан өртөг, тарифтай харьцуулсан санхүүгийн дүн шинжилгээ, өртөг зардлын үр ашгийн судалгаа хийсэн байдал	20%
7	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэв ЭМДЕГ-тай өмнө нь байгуулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн үр дүнд дүн шинжилгээ хийж, сайжруулах арга хэмжээг төлөвлөсөн байдал, санхүүгийн үр ашиг, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ	10%
8	Цахим бэлэн байдал	ЭМД-ийн системд холбогдсон байдал, мэдээллийн нээлттэй байдал	10%
Бүгд			100%

4.5 Сонгон шалгаруулалтаар зарласан тусламж, үйлчилгээг үзүүлэх нөөц, хүчин чадал, чадавх, чадамжийг үнэлэх ерөнхий шалгуур тус бүрд хамаарах шалгуур үзүүлэлтийг ЭМДЕГ тогтоож, даргын тушаалаар баталж үнэлгээнд ашиглана.

4.6 Сонгон шалгаруулалтаар зарласан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлыг нь хариуцах тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад заагдсан тусламж, үйлчилгээг бүрд хамаарах нарийвчилсан шалгуурыг “нэмэлт шалгуур” гэх бөгөөд уг шалгуурыг ЭМДЕГ тогтоож, даргын тушаалаар баталж сонгон шалгаруулалтын үнэлгээнд ашиглана.

4.7 Сонгон шалгаруулалтаар зарласан тусламж, үйлчилгээг үзүүлэх ерөнхий шалгуур, нэмэлт шалгуурыг тогтоохдоо газар зүйн байршил, тусламж, үйлчилгээний хүртээмж, тэгш байдлыг харгалзах бөгөөд орон нутаг, алслагдмал бүс нутагт байршилтай тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн нөөц, хүчин чадал, чадавх, чадамжийг үнэлэх ерөнхий шалгуур, нэмэлт шалгуурыг зөөлрүүлж нийслэлд байршилтай тусламж, үйлчилгээ үзүүлэгчээс ялгаатай тогтооно.

4.8 Сонгон шалгаруулалтаар зарлах эрүүл мэндийн даатгалын сангаас зардлыг нь хариуцах тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад заагдсан

тусламж, үйлчилгээг бүрд хамаарах нэмэлт шалгуурыг тогтоохдоо дараах байдлаар төрөлжүүлэн тогтооно.

4.8.1 Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний эмийн эмчилгээний оношийн хамааралтай бүлэгт хамаарах зарим тусламж, үйлчилгээний нийт хэрэгцээг тодорхойлж, эрүүл мэндийн даатгалын сангаас зардлыг нь хариуцах нийт тоо хэмжээг зарлаж өрсөлдүүлэх тусламж, үйлчилгээний багц

4.8.2 Хүсэлт гаргасан тохиолдолд шууд сонгох тусламж, үйлчилгээний багц

4.8.3 Цогцоор нь үзүүлэх шаардлагатай тусламж, үйлчилгээний багц

4.8.4 Хэвтүүлэн эмчлэх мэс заслын оношийн хамааралтай бүлэгтэй хамтаар зайлшгүй үзүүлэх тусламж, үйлчилгээний багц

4.8.5 Дангаар үзүүлэхээр хүсэлт гаргаж болохгүй тусламж, үйлчилгээний багц

4.8.6 Өндөртэй өртөгтэй тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлэгтэй хамтаар зайлшгүй үзүүлэх шаардлагатай тусламж, үйлчилгээний багц

4.8.7 Өдрийн эмчилгээ, өдрийн мэс заслын тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлэгтэй хамтаар зайлшгүй үзүүлэх шаардлагатай тусламж, үйлчилгээний багц

4.8.8 Сэргээн засах тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлэгтэй хамтаар зайлшгүй үзүүлэх шаардлагатай тусламж, үйлчилгээний багц

4.8.9 Эмнэлгийн тусламж, үйлчилгээний (хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, орон нутгийн өмчит нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв)-д заасан эрүүл мэндийн байгууллагын үзүүлэх тусламж, үйлчилгээний багц

4.8.10 30-аас доош ортой тусламж, үйлчилгээ үзүүлэгчээс үзүүлэх тусламж, үйлчилгээний багц

4.8.11 Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийг цогцоор нь үзүүлэх тусламж, үйлчилгээний багц

4.8.12 Сувилаас үзүүлэх тусламж, үйлчилгээний багц

4.8.13 Дагнасан төрлийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг тусламж, үйлчилгээ үзүүлэгчээс үзүүлэх тусламж, үйлчилгээний багц

4.8.14 Алслагдмал бүс нутгийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчээс үзүүлэх тусламж, үйлчилгээний багц

4.8.15 Эрүүл мэндийн даатгалаас зардлыг нь хариуцах тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад заагдсан төлбөрөөс өөр нэмэлт төлбөр авч болохгүй тусламж, үйлчилгээний багц

4.9 Эрүүл мэндийн тухай хуулийн 16.16-т заасан төрийн өмчийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, үндэсний төв нь сонгон шалгаруулалтаар зарласан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлыг нь хариуцах тусламж, үйлчилгээг улсын хэмжээнд ганцаараа дагнан үзүүлдэг тохиолдолд сонгон шалгаруулалтын хоёрдугаар үе шатанд тэнцсэн байвал сонгон шалгаруулалтын гуравдугаар үе шатыг алгасан сонгон шалгаруулалтад тэнцсэн тухай мэдэгдлийг үнэлгээний нэгдсэн дүгнэлт гарч, ЭМДЕГ-ын даргын тушаалаар баталгаажсанаас хойш ажлын 3 хоногт багтаан тухайн байгууллагын албан ёсны цахим хаягаар хүргүүлнэ.

Тав. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа

5.1 Сонгон шалгаруулалт зарлах

5.1.1 Сонгон шалгаруулалтын зарыг ЭМДЕГ-ын цахим хуудсаар болон олон нийтийн мэдээллийн албан ёсны мэдээллийн хэрэгслээр ил тод, нээлттэй зарлана.

5.1.2 Сонгон шалгаруулалтын урилгыг энэхүү журмын 3.1-т заасан урьдчилсан нөхцөлтэй холбоотой материалыг хүлээн авч эхлэх өдрөөс 7 -оос доошгүй хоногийн өмнө байршуулна.

5.1.3 Сонгон шалгаруулалтын урилгын загварыг ЭМДЕГ-ын даргын тушаалаар батална.

5.2 Сонгон шалгаруулалтын үйл явц

5.2.1 Сонгон шалгаруулалтад оролцохоор хүсэлт гаргасан тусламж, үйлчилгээ үзүүлэгчид тавигдах урьдчилсан нөхцөл холбоотой баримт бичиг, материалыг үнэлэх үе шат

5.2.1.1 Тусламж, үйлчилгээ үзүүлэгчид тавигдах урьдчилсан нөхцөлтэй холбоотой материалыг тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас сонгон шалгаруулалт зарласнаас хойш ажлын 10 хоногийн хугацаанд цахим системээр хүлээн авч үнэлгээг ажлын 7 хоногт багтаан цахимаар зохион байгуулна.

5.2.1.2 Тусламж, үйлчилгээ үзүүлэгчид тавигдах урьдчилсан нөхцөлтэй холбоотой материалыг хэрхэн үнэлэх үнэлгээний дэлгэрэнгүй зааврыг ЭМДЕГ нь сонгон шалгаруулалтад оролцохоор хүсэлт гаргасан тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад цахимаар илгээсэн байна.

5.2.1.3 Тусламж, үйлчилгээ үзүүлэгчид тавигдах урьдчилсан нөхцөлийг бүрэн хангасан тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг тухайн үе шатны үнэлгээнд тэнцсэнд тооцно.

5.2.1.4 Тусламж, үйлчилгээ үзүүлэгчид тавигдах урьдчилсан нөхцөл холбоотой баримт бичиг, материалыг үнэлэх үе шатанд тэнцсэн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад сонгон шалгаруулалтын дараагийн үе шатанд оролцох эрхийг цахимаар илгээнэ.

5.2.1.5 Тусламж, үйлчилгээ үзүүлэгчид тавигдах урьдчилсан нөхцөл холбоотой баримт бичиг, материалыг үнэлэх үе шатанд тэнцээгүй байгууллагад тэнцээгүй тухай мэдэгдлийг үнэлгээ дууссан хугацаанаас хойш ажлын 3 хоногт багтаан тухайн байгууллагын албан ёсны цахим хаягаар илгээнэ.

5.2.2 Сонгон шалгаруулалтын нэгдүгээр буюу тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн байгууллагын үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хүлээн авах үе шат

5.2.2.1 Тусламж, үйлчилгээ үзүүлэгчид тавигдах урьдчилсан нөхцөл холбоотой баримт бичиг, материалыг үнэлэх үе шатанд тэнцсэн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь сонгон шалгаруулалтын нэгдүгээр үе шатанд оролцоно.

5.2.2.2 Энэхүү журмын 5.2.1.4-т заасан цахим мэдэгдлийг хүлээн авсан тусламж, үйлчилгээ үзүүлэгч нь мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 15 хоногийн дотор багтаан энэхүү журмын нэгдүгээр хавсралтад заагдсан хүснэгтийн загварт туссан мэдээллийг цахим системд оруулж баталгаажуулна.

5.2.2.3 Тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн байгууллагын үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цахим системд хэрхэн оруулах, хэрхэн үнэлэх тухай заавар аргачлалыг сонгон шалгаруулалтад оролцож байгаа тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад цахим системээр урьдчилж илгээсэн байна.

5.2.2.4 Тусламж, үйлчилгээ үзүүлэгч өөрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг бүрэн гүйцэд оруулж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулсан тухай мэдэгдлийг цахим системээр илгээнэ.

5.2.2.5 ЭМДЕГ нь 5.2.2.4-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногт багтаан мэдээллийг үнэлж тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад дараагийн шатны сонгон шалгаруулалтад оролцох урилгыг цахимаар хүргүүлнэ.

5.2.2.6 Тусламж, үйлчилгээ үзүүлэгч өөрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү журмын нэгдүгээр хавсралтад заасан хүснэгтийн загварт туссан мэдээллийг бүрэн гүйцэд оруулаагүй тохиолдолд мэдээллийг үнэлэхгүй бөгөөд 5.2.2.4-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан энэ тухай цахим системээр хариу мэдэгдэнэ.

5.2.2.7 Тусламж, үйлчилгээ үзүүлэгч өөрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг бүрэн гүйцэд оруулаагүй тухай мэдэгдэл хүлээн авсан тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад холбогдох мэдээллийг ажлын 3 хоногт багтаан гүйцээж оруулах нэг удаагийн боломжийг олгож энэхүү журмын 5.2.2.5-т заасны дагуу шийдвэрлэнэ.

5.2.3 Сонгон шалгаруулалтын хоёрдугаар буюу сонгон шалгаруулалтаар зарласан тусламж, үйлчилгээний төрлийн хүрээнд тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын оролцохоор хүсэлт гаргасан тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах нөөц, хүчин чадал, чадавх, чадамжийн ерөнхий шалгуурыг үнэлэх үе шат

5.2.3.1 Энэхүү журмын 5.2.2.5, 5.2.2.7 заасан цахим мэдэгдлийг хүлээн авсан тусламж, үйлчилгээ үзүүлэгч нь мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 15 хоногийн дотор багтаан тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах нөөц, хүчин чадал, чадавх, чадамжийн ерөнхий шалгуурыг үнэлэх ЭМДЕГ-ын даргын тушаалаар тогтоосон шалгуур үзүүлэлттэй холбоотой мэдээллийг цахимаар системд оруулж баталгаажуулна.

5.2.3.2 Нөөц, хүчин чадал, чадавх, чадамжийн ерөнхий шалгуурыг үнэлэх шалгуур үзүүлэлттэй холбоотой мэдээллийг цахим системд хэрхэн оруулах, шалгуур үзүүлэлт тус бүрийг хэрхэн үнэлэх тухай заавар, аргачлалыг сонгон шалгаруулалтад оролцож байгаа тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад цахим системээр урьдчилж илгээсэн байна.

5.2.3.3 Нөөц, хүчин чадал, чадавх, чадамжийн ерөнхий шалгуурыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг 80-100 хувь хангасан тусламж, үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулалтын хоёрдугаар үе шатанд тэнцсэнд тооцож, тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад сонгон шалгаруулалтын гуравдугаар үе шатанд оролцох урилгыг цахим системээр үнэлгээ дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан илгээнэ.

5.2.3.4 Нөөц, хүчин чадал, чадавх, чадамжийн ерөнхий шалгуурыг үнэлэх шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 80-аас доош хувийг хангасан тусламж, үйлчилгээ үзүүлэгчид сонгон шалгаруулалтын хоёрдугаар үе шатанд тэнцээгүй буюу сонгон шалгаруулалтаас хасагдсан тухай мэдэгдлийг үнэлгээ дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан цахим системээр илгээнэ.

5.2.3.5 Сонгон шалгаруулалтын хоёрдугаар үе шатанд тэнцээгүй буюу сонгон шалгаруулалтаас хасагдах тухай мэдэгдэл хүлээн авсан тусламж, үйлчилгээ үзүүлэгч нь мэдэгдлийг хүлээн зөвшөөрөөгүй тухай гомдлыг ЭМДЕГ-т мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан албан ёсоор гаргах бөгөөд ЭМДЕГ нь сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсгээс ангид хөндлөнгийн багаар хөндлөнгийн хяналтыг гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан гүйцэтгүүлж тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад цахим системээр албан ёсоор мэдэгдэнэ.

5.2.3.6 Хэрэв энэхүү журмын 5.2.3.5-т заасан өргөдөл нь хөндлөнгийн үнэлгээгээр үндэслэлтэй болох нь тогтоогдсон тохиолдолд тусламж, үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулалтын хоёрдугаар үе шатанд тэнцсэнд тооцож, тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад сонгон шалгаруулалтын гуравдугаар үе шатанд оролцох урилгыг цахим системээр хөндлөнгийн дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан илгээнэ.

5.2.4 Сонгон шалгаруулалтын гуравдугаар буюу үе шат

5.2.4.1 Сонгон шалгаруулалтаар зарласан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлыг нь хариуцах тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад

заагдсан тусламж, үйлчилгээ бүрд хамаарах нэмэлт шалгуурыг үнэлэхдээ энэхүү журмын 4.8-ийн хүрээнд тогтоосон тусламж, үйлчилгээний багцын ЭМДЕГ-ын даргын тушаалаар баталсан нэмэлт шалгуурын хүрээнд үнэлнэ.

5.2.4.2 Энэхүү журмын 5.2.3.3, 5.2.3.6-т заасан цахим мэдэгдлийг хүлээн авсан тусламж, үйлчилгээ үзүүлэгч нь мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 15 хоногийн дотор багтаан сонгон шалгаруулалтаар зарласан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлыг нь хариуцах тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад заагдсан тусламж, үйлчилгээ бүрд хамаарах ЭМДЕГ-ын даргын тушаалаар тогтоосон нэмэлт шалгууртай холбоотой мэдээллийг цахимаар системд оруулж баталгаажуулна.

5.2.4.3 Сонгон шалгаруулалтаар зарласан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлыг нь хариуцах тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад заагдсан тусламж, үйлчилгээ бүрд хамаарах үнэлэх нэмэлт шалгууртай холбоотой мэдээллийг цахим системд хэрхэн оруулах, шалгуур тус бүрийг хэрхэн үнэлэх тухай заавар, аргачлалыг сонгон шалгаруулалтад оролцож байгаа тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад цахим системээр урьдчилж илгээсэн байна.

5.2.4.4 Сонгон шалгаруулалтын гуравдугаар үе шатны үнэлгээ буюу мэдээллийн бүрэн бүтэн байдлын үнэлгээг мэдээлэл хүлээн авч дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор зохион байгуулна.

5.2.4.5 Сонгон шалгаруулалтын гуравдугаар үе шатанд тэнцсэн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад сонгон шалгаруулалтад тэнцсэн тухай мэдэгдлийг үнэлгээний нэгдсэн дүгнэлт гарч, ЭМДЕГ-ын даргын тушаалаар баталгаажсанаас хойш ажлын 3 хоногт багтаан тухайн байгууллагын албан ёсны цахим хаягаар хүргүүлнэ.

5.3 ЭМДЕГ-ын сонгон шалгаруулалтыг хариуцах чиг үүргийг хэрэгжүүлэг нэгж нь сонгон шалгаруулалт дууссанаас хойш ажлын 14 хоногт багтаан сонгон шалгаруулалтын үр дүн, хүн амд үзүүлэх эрүүл мэндийн даатгалын сангаас нь зардлыг нь хариуцах тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээ, хүртээмж, тэгш байдлыг хэрхэн хангасан тухай дүгнэсэн санал дүгнэлтийг боловсруулж танилцуулна.

5.4 Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн даатгалын сангаас нь зардлыг нь хариуцах тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээ, хүртээмж, тэгш байдлын дүгнэлтэд үндэслэн нэмэлт сонгон шалгаруулалт зарлах тухай шийдвэрийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл гаргах бөгөөд сонгон шалгаруулалтыг энэ журмын зохицуулалтаас өөрөөр хялбарчилсан байдлаар зохион байгуулна.

5.5 Сонгон шалгаруулалтыг ЭМДЕГ-ын сонгон шалгаруулалтын чиг үүрийг хэрэгжүүлдэг нэгж удирдлага, зохион байгуулалтаар хангах ба ашиг сонирхлын зөрчилгүй, олон талт төлөөлөл бүхий ажлын хэсгийг бусад нэгжийн оролцоотой өргөн хүрээнд байгуулж, даргын тушаалаар томилж ажиллуулна.

Зургаа. Сонгон шалгаруулалтын үр дүнг баталгаажуулах, мэдээлэх

6.1 ЭМДЕГ-ын дарга сонгон шалгаруулалтын гуравдугаар үе шатны үнэлгээ хийгдэж дууссанаас хойш ажлын 10 хоногийн дотор тушаал гаргаж, сонгон шалгаруулалтын үр дүнг баталгаажуулна.

6.2 Сонгон шалгаруулалтад тэнцсэн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг газар зүйн байршлаар нь ангилж жагсаалт үүсгэх ба байгууллага тус бүрийн үзүүлэхээр тэнцсэн тусламж, үйлчилгээний дэлгэрэнгүй жагсаалтын хамт ЭМДЕГ-ын цахим хуудсанд албан ёсоор байршуулна.

6.3 ЭМДЕГ нь сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан тухай тайланг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад энэ журмын 6.1-т заасан тушаал гарснаас хойш хуанлийн 30 хоногийн дотор хүргүүлнэ.

6.3 Энэхүү журмын 6.1-т заасан тушаал гарснаас хойш хуанлийн 15 хоногт багтаан сонгон шалгаруулалтад тэнцсэн тусламж, үйлчилгээний төрлөөр Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т заасны дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс баталсан гэрээний үлгэрчилсэн загварыг баримтлан байгуулна.

Долоо. Ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх

7.1 Сонгон шалгаруулалтад оролцсон этгээдүүд ашиг сонирхлын мэдүүлэг гаргана.

7.2 Үнэлгээний ажлын хэсгийн гишүүдийг ашиг сонирхлын зөрчилгүй байдлыг хангаж томилно.

7.3 Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ЭМДЕГ-ын удирдлагын оролцоог хязгаарлаж, хөндлөнгийн шинжээч томилж оролцуулна.

Найм. Сонгон шалгаруулалттай холбоотой маргааныг шийдвэрлэх

8.1 Сонгон шалгаруулалттай холбоотой маргааныг хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

8.2 Энэхүү журмыг шинэчлэх, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг ЭМДЕГ хэрэгжүүлнэ.

Ес. Хариуцлага